



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын 2 дугаарт заасныг үндэслэн ТУШААХ нь:

Зам, тээврийн сайдын 2014 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 116 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын хүрээнд Зам, тээврийн яам болон харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын 2.3.1 дэх заалтыг дараах хэлбэрээр өөрчилсүгэй.

“2.3.1 Арга хэмжээний хэрэгжилт нь төлөвлөсөн хугацаанаас хэтэрсэн бол хасах итгэлцүүр тооцох ба энэ нь үе шатны хуваарийн дагуу өгсөн үнэлгээний 30 хүртэл хувийн оноо хасч үнэлнэ. Хэрэгжих хугацаа нь санхүүжилт болон хамтран хэрэгжүүлэгч салбарын бус байгууллагаас шалтгаалан хоцорсон арга хэмжээнд энэ заалт хамаарахгүй.”

САЙД



М.ЗОРИГТ